



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд хэрэгжих хөрөнгө оруулалт тохижилт, бүтээн байгуулалтын ажлууд, инженерийн хангамжийн байгууллагууд болон хот нийтийн аж ахуйн өдөр тутмын үйл ажиллагаанд мэдээлэл технологийн шинэ шийдлийг нэвтрүүлж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн санг нэгтгэх, хот нийтийн аж ахуй өдөр тутмын үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүд, инженер, техникийн ажилтнуудын үйл ажиллагааг хялбаршуулж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, цахимжуулах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавих зорилгоор Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем "UB ENGINEERING"-ийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ашиглалтад оруулах, холбогдох журам боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан ажлын хэсгийн явц, үр дүнг тогтмол тайлагнаж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200849

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 09 өдрийн
АИ 15.2 дугаар захирамжийн
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
Ажлын хэсгийн дэд ахлагч:	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга.
Гишүүд:	Барилга, хот байгуулалтын яамны Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр); Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга; Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга; Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга; Нийслэлийн Архивын газрын дарга; "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирал (зөвшилцсөнөөр); Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч; Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч; Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч; Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч; Багахангай дүүргийн Засаг даргын орлогч; Багануур дүүргийн Засаг даргын орлогч; Баянгол дүүргийн Засаг даргын орлогч; Налайх дүүргийн Засаг даргын орлогч; Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч;

Хотын стандарт, хяналтын газрын дарга;

Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга;

Нийслэлийн дотоод аудитын албаны дарга;

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга;

Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга;

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга;

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга;

"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын дарга;

"Ус сувгийн Удирдах газар" ОНӨААТҮГ-ын дарга;

"Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв" ОНӨТҮГ-ын дарга;

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн захирал;

"Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал;

"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-н дарга;

"Улаанбаатар лифт" ОНӨТҮГ-ын дарга;

"Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын захирал;

Монголын Барилгын зураг төсөл зохиогчдын холбооны удирдах зөвлөлийн дарга бөгөөд ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр);

Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр);

Нарийн бичгийн дарга:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн Газарзүйн мэдээллийн систем, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтсийн дарга